



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 64

Мандалговь

Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч,
төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын
сонгон шалгаруулалтууд зохион байгуулах
комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4, 33.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3.2, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Адаацаг сумын Цэцэрлэгийн эрхлэгч, Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: А.Лхагвасүрэн –(Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн Тамгын газрын дарга)

Гишүүд: Н.Эрдэнэ-Очир- (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
М.Болор-Эрдэнэ–(Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Б.Хандмаа —(Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С.Хулан – (Салбар зөвлөлийн гишүүн, ТАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга)

2. “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-нд тус тус заасан сонгон шалгаруулах комиссын чиг үүргийг хэрэгжүүлэн, шалгалтын бэлтгэлийг ханган зохион байгуулж, холбогдох мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг комисс (А.Лхагвасүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ

